



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А167

Улаанбаатар хот

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын барилгын бүртгэлийн үнийг нэмэгдүүлэх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр тус газрын балансад бүртгэлтэй офиссын барилгад хийгдсэн их засварыг нийт 56,050,000.00 (тавин зургаан сая тавин мянга) төгрөгөөр барилгын бүртгэлийн үнийг нэмэгдүүлэн данс бүртгэлдээ бүртгэн авахыг Ерөнхий нягтлан бодогч (Т.Оюунтуул)-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу данс бүртгэлдээ бүртгэн, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Ерөнхий нягтлан бодогч (Т.Оюунтуул)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА